

ХААН СОЁМБО АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Тариалан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/55/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2023 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням
Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn

Хаан соёмбо аудит ХХК-ын захирал: Х.Диймаа
Утас: 99065668 Цахим хаяг: info@khaansoyomboaudit.mn

Гүйцэтгэсэн аудитын менежер: Л.Магсаржалам
Утас: 88114867 Цахим хаяг: khaan.soyombo.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	13
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
3.5.1 Төсвийн төлөвлөлт	15
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	16
3.5.3 Нэмэлт төсөв	16
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн	16
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
5.1 Төлбөрийн акт	18
5.2 Албан шаардлага	18
5.3 Зөвлөмж	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvs gul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.02.24 № 01/126
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТАРИАЛАН
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Д.ДУЛАМСҮРЭН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тариалан сумын Эрүүл Мэндийн Төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тариалан сумын Эрүүл Мэндийн Төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэлийг 2022 оны 1 дүгээр сарын 1-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд зарцуулах хөрөнгийг эрүүл мэндийн даатгалын санд нэгтгэж, гүйцэтгэлд суурилж санхүүжүүлсэн байна. Тус байгууллага нь гүйцэтгэлээр санхүүжилт авсан боловч мөнгөн хөрөнгийн дансанд 117,580.3 мянган төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдэлтэй байна.

Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийг гүйцэтгэлд суурилж олгож байгаагаас шалтгаалан, санхүүжилтийн орлого нэмэгдэж ирснээр дахин эмийн тендер зарлаж, худалдан авалт хийх шаадлагатай байсан ч, тухайн сумын Эрүүл мэндийн төв нь 83,780.6 мянган төгрөгийн тендергүй эмийн худалдан авалт, 46,730.2 мянган төгрөгийн багаж тоног төхөөрөмжийг шууд худалдан авалт хийсэн, хүнсний материалыг сарын бодит хэрэглээнээс илүү худалдан авалт хийсэн, Нийгмийн эрүүл мэндийн зардлаас хүүхдийн сувилал ажиллуулсан, ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, гэр бүлийн тэмцээн зохион байгуулах, үдийн цай, хоол гэх мэт үр ашиггүй зардал гаргасан байна.

Бусад асуудлын хэсэг

Тариалан сумын Эрүүл Мэндийн Төв нь 2022 онд 4 хөтөлбөр, 22 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж 98.1 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх

үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

СТ-1А

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	240,113,253.54	232,597,920.92
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	117,580,302.72
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	117,580,302.72
3121	Төгрөг	00.00	117,580,302.72
31211	Төрийн сангийн харилцах	00.00	117,580,302.72
33	АВЛАГА	168,836,579.62	00.00
33100	Ажиллагсадтай холбогдсон авлаг	456,679.62	00.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	168,379,900	
35	БАРАА МАТЕРИАЛ	71,276,673.92	115,017,617.92
351	Түүхий эд материал	23,654,732.92	31,126,421.74
35130	Эм боох материал	23,654,732.92	31,126,421.74
354	Хангамжийн материал	46,831,414.00	83,100,669.18
35410	Бичиг хэргийн материал	1,321,610.00	3,156,560.00
35420	Аж ахуйн материал	18,253,468.00	24,414,876.43
35430	Сэлбэг хэрэгсэл		1,432,400.00
35450	Барилгын засварын материал	00.00	00.00
35460	Хүнсний материал	4,180,086.00	5,297,421.00
35470	Бусад хангамжийн материал	18,576,250.00	46,788,161.75
35600	Мал амьтад	790,527.00	790527.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	676,686,412.59	726,419,514.78
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	676,686,412.59	726,419,514.78
392	Биет хөрөнгө	653,049,212.59	702,979,814.86
39201	Барилга, байгууламж, орон сууц	529,750,778.81	544,750,778.81
39202	Хуримтлагдсан элэгдэл	(84,594,740.48)	(105,066,483.65)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	62,429,692.00	65,575,692.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(26,657,489.20)	(34,532,946.79)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	183,156,041.00	289,187,699.31
39206	Хуримтлагдсан элэгдэл	(40,307,951.78)	(84,287,626.05)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	47,164,437.00	53,326,959.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(17,891,554.76)	(25,974,257.77)
39214	Бусад үндсэн хөрөнгө	00.00	00.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	00.00	00.00
393	Биет бус хөрөнгө	23,637,200.00	23,439,699.92
39301	Програм хангамж	725,000.00	725,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл		(197,500.08)
39303	Бусад биет бус хөрөнгө	22,912,200.00	22,912,200.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	916,799,666.13	959,017,435.42
	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	0.00	100,196.00
	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	100,196.00
413	Өглөг	0.00	100,196.00
4136	Байгууллагад төлөх өглөг	0.00	100,196.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	916,799,666.13	958,917,239.70
51	Засгийн газрын хувь оролцоо	916,799,666.13	958,917,239.70
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	332,460,354.00	332,460,354.00
51101	Өмч: - төрийн	332,460,354.00	332,460,354.00
512	Хуримтлагдсан үр дүн	160,681,510.81	202,799,084.38

Хөвсгөл аймгийн Тариалан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

51210	Өмнөх үеийн үр дүн	160,681,510.81	160,681,510.81
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	42,117,573.29
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	423,657,801.32	423,657,801.32
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	916,799,666.13	959,017,435.42

2.2 Санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,852,694,471.16	1,253,691,753.86
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	547,159,011.16	174,642,243.86
120	Нийтлэг татварын бус орлого	547,159,011.16	174,642,243.86
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	547,159,011.16	174,642,243.86
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	498,249,600.00	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	719,692,700.00	1,019,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	4534500	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	52,088,200.00	1,019,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,415,000.00	0.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	658,655,000.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	44,108,600.00	49,266,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	44,108,600.00	49,266,100.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	43,484,560.00	1,028,764,410.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	43,484,560.00	1,028,764,410.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,589,568,886.80	1,211,574,180.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,548,618,886.80	1,211,006,592.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,548,618,886.80	1,211,006,592.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	570,672,565.00	633,724,250.00
210101	Үндсэн цалин	335,651,665.00	381,140,918.00
210102	Нэмэгдэл	170,256,900.00	183,769,330.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		6,511,000.00
210104	Урамшуулал	61,074,000.00	60,253,449.00
210105	Гэрээт ажлын хөлс	3,690,000.00	2,049,553.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	73,546,800.38	80,356,816.41
210201	Тэтгэврийн даатгал	50,974,400.38	55,568,276.87
210202	Тэтгэмжийн даатгал	5,643,125.00	6,288,391.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,514,440.00	5,005,410.13
210204	Ажилгүйдлийн даатгал	1,128,585	1,047,756.22
210205	Эрүүл мэндийн даатгал	11,286,250.00	12,446,981.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,480,023.00	43,108,600.00
210301	Гэрэл, цахилгаан	2,962,823.00	3,002,498.00
210302	Түлш, халаалт	36,517,200.00	38,106,102.00
210303	Цэвэр, бохир усны зардал	2,000,000.00	2,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	72,600,452.17	74,271,299.49
210401	Бичиг хэрэг	2,813,500.00	2,226,400.00
210402	Тээвэр, шатахуун	41,879,905.00	47,788,870.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,742,016.00	4,081,999.49
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,832,600.00	5,709,400.00

Хөвсгөл аймгийн Тариалан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,587,800.00	14,464,630.00
210408	Бараа материал акталсны зардал	6,744,631.17	0.00
2105	Нормативт зардал	687,033,458.23	245,198,520.55
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	627,910,327.23	215,889,313.55
210502	Хоол, хүнс	59,123,131.00	29,309,207.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,500,000.00	19,495,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	1,000,000.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	10,500,000.00	14,495,000.00
2107	Томилолт, зочны зардал	540,000.00	2,939,000.00
210702	Дотоод албан томилолт	540,000.00	2,939,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,327,668.00	11,388,278.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,958,100.00	7,766,192.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000	2,231,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	150,000.00	162,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	68,000.00	74,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	32,936.00
210807	Газрын төлбөр	71,568.00	79,300.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	636,000.00	1,042,250.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	73,917,920.02	100,524,828.12
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,234,000.0	19,917,750.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	71,683,920.02	80,607,078.12
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40,950,000.00	567,588.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	40,950,000.00	00.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	40,600,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	350,000.00	00.00
	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		567,588.00
	Төвлөрүүлэх шилжүүлэг		567,588.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	263,125,584.36	42,117,573.29
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,687,740.82	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	3,687,740.82	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(3,687,740.82)	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	259,437,843.54	42,117,573.29

2.3 Мөнгөн гүйлгээний тайлан

СТ-3А

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,137,505,560.00	1,247,429,410.00
12	Татварын бус орлого		200,303,900.00
120	Төсөвт байгууллагын өөрийн орлого		200,303,900.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		200,303,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,137,505,560.00	1,047,125,510.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	498,249,600.00	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	551,662,800.00	0.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	4,534,500.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	52,438,200.00	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,415,000.00	0.00

Хөвсгөл аймгийн Тариалан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	490,275,100.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	44,108,600.00	49,266,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	44,108,600.00	49,266,100.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	43,484,560.00	997,859,410.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	43,484,560.00	997,859,410.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,127,035,560.00	1,087,264,107.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,127,035,560.00	1,087,264,107.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,086,085,560.00	1,086,696,519.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	570,672,565.00	633,723,250.00
210101	Үндсэн цалин	335,651,665.00	381,082,328.00
210102	Нэмэгдэл	170,256,900.00	183,769,330.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	6,511,000.00
210104	Урамшуулал	61,074,000.00	60,312,039.00
210105	Гэрээт ажлын хөлс	3,690,000.00	2,048,553.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	74,003,480.00	79,901,136.79
210201	Тэтгэврийн даатгал	51,431,080.00	55,198,586.39
210202	Тэтгэмжийн даатгал	5,643,125.00	6,298,506.81
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,514,440.00	5,014,171.81
210204	Ажилгүйдлийн даатгал	1,128,585.00	1,226,148.19
210205	Эрүүл мэндийн даатгал	11,286,250.00	12,163,723.59
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,571,423.00	40,608,600.00
210301	Гэрэл, цахилгаан	2,962,823.00	3,002,498.00
210302	Түлш, халаалт	40,608,600.00	35,606,102.00
210303	Цэвэр, бохир усны зардал	2,000,000.00	2,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	63,458,071.00	82,325,119.49
210401	Бичиг хэрэг	2,934,300.00	3,821,100.00
210402	Тээвэр, шатахуун	41,879,905.00	47,800,120.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,742,016.00	4,081,999.49
210404	Ном, хэвлэл	165,000.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,832,600.00	7,729,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,904,250.00	18,892,800.00
2105	Нормативт зардал	300,778,353.00	194,865,931.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	236,340,459.00	141,944,389.00
210502	Хоол, хүнс	62,437,894.00	30,426,542.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,000,000.00	22,495,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,500,000.00	20,927,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		1,432,400.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,000,000.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	10,500,000.00	14,495,000.00
2107	Томилолт, зочны зардал	540,000.00	2,939,000.00
210702	Дотоод албан томилолт	540,000.00	2,939,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,327,668.00	11,323,332.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,958,100.00	7,665,996.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	2,231,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	150,000.00	162,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	68,000.00	74,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	32,936.00
210807	Газрын төлбөр	71,568.00	79,300.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	636,000.00	1,077,500.00

Хөвсгөл аймгийн Тариалан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,234,000.00	20,082,750.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,234,000.00	20,082,750.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40,950,000.00	567,588.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	40,950,000.00	
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	40,600,000.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	350,000.00	
	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		567,588.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		567,588.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	10,470,000.00	160,165,302.72
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	10,470,000.00	42,585,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,470,000.00	42,585,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	10,470,000.00	42,585,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	10,470,000.00	42,585,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)		
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		117,580,302.72
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		117,580,302.72

2.4 Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	332,460,354.00	430,241,795.15	-105,340,326.56	657,361,822.59
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	332,460,354.00	430,241,795.15	-105,340,326.56	657,361,822.59
C07	Тайлант үеийн үр дүн				
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	332,460,354.00	432,657,801.32	160,681,510.81	916,799,666.13
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	332,460,354.00	423,657,801.32	160,681,510.81	916,799,666.13
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	332,460,354.00	423,657,801.32	160,681,510.81	916,799,666.13
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн			42,117,573.29	42,117,573.29
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	332,460,354.00	423,657,801.32	202,799,084.10	958,917,239.42

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,185,371,100.00	1,129,281,519.00	56,089,581.00	95.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,185,371,100.00	1,129,281,519.00	56,089,581.00	95.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,185,371,100.00	1,129,281,519.00	56,089,581.00	95.27
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	664,288,700.00	633,723,250.00	30,565,450.00	95.40
210101	Үндсэн цалин	442,498,500.00	381,082,328.00	61,416,172.00	86.12
210102	Нэмэгдэл	148,927,100.00	183,769,330.00	(34,842,230.00)	123.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,500,000.00	6,511,000.00	989,000.00	86.81
210104	Урамшуулал	60,000,000.00	60,312,039.00	(312,039.00)	100.42
210105	Гэрээт ажлын хөлс	5,363,100.00	2,048,553.00	3,314,547.00	38.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	83,060,200.00	79,901,136.51	3,159,063.49	96.20
210201	Тэтгэврийн даатгал	56,511,300.00	55,198,586.39	1,312,713.61	97.68
210202	Тэтгэмжийн даатгал	6,608,300.00	6,298,506.81	309,793.19	95.31
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,318,500.00	5,014,171.81	304,328.19	94.28
210204	Ажилгүйдлийн даатгал	1,325,300.00	1,226,147.91	99,152.09	92.52
210205	Эрүүл мэндийн даатгал	13,296,800.00	12,163,723.59	1,133,076.41	91.48
	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,608,600.00	40,608,600.00	-	100.00
210301	Гэрэл цахилгаан	2,500,000.00	3,002,498.00	(502,498.00)	120.10
210302	Түлш, халаалт	36,108,600.00	35,606,102.00	502,498.00	98.61
210303	Цэвэр, бохир ус	2,000,000.00	2,000,000.00	-	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	90,000,900.00	82,325,119.49	7,675,780.51	91.47
210401	Бичиг хэрэг	4,333,900.00	3,821,100.00	512,800.00	88.17
210402	Тээвэр, шатахуун	47,827,600.00	47,800,120.00	27,480.00	99.94
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,673,600.00	4,081,999.49	1,591,600.51	71.95
210404	Ном хэвлэл	458,600.00	0.00	458,600.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	11,707,900.00	7,729,100.00	3,978,800.00	66.02
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	19,999,300.00	18,892,800.00	1,106,500.00	94.47
2105	Нормативт зардал	202,720,700.00	194,865,931.00	7,854,769.00	96.13
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	143,119,100.00	141,944,389.00	1,174,711.00	99.18
210502	Хоол, хүнс	35,434,500.00	30,426,542.00	5,007,958.00	85.87
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	24,167,100.00	22,495,000.00	1,672,100.00	93.08
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	65,124,700.00	63,512,400.00	1,612,300.00	97.52
210601	Багаж, техник хэрэгсэл	43,114,400.00	44,017,400.00	(903,000.00)	102.09
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	6,082,900.00	5,000,000.00	1,082,900.00	82.20
210604	Урсгал засвар	15,927,400.00	14,495,000.00	1,432,400.00	91.01
2107	Томилолт, зочны зардал	3,564,700.00	2,939,000.00	625,700.00	82.45
210702	Дотоод албан томилолт	3,564,700.00	2,939,000.00	625,700.00	82.45

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,913,900.00	11,323,332.00	4,590,568.00	71.15
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,236,000.00	7,665,996.00	4,570,004.00	62.65
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,231,000.00	2,231,000.00	-	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	162,500.00	162,500.00	-	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	74,100.00	74,100.00	-	100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	48,100.00	32,936.00	15,164.00	68.47
210807	Газрын төлбөр	79,300.00	79,300.00		100.00-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,082,900.00	1,077,500.00	5,400.00	99.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,088,700.00	20,082,750.00	5,950.00	99.97
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,088,700.00	20,082,750.00	5,950.00	99.97
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,185,371,100.00	1,246,861,822.0	-62,058,310.00	106.6
132001	Орон нутгийн төсвөөс	49,266,100.00	48,698,512.0	567,588.0	100.0
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,136,105,000.0	1,198,163,310.00	-62,058,310.00	106.6
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	935,801,100.00	997,859,410.00	-62,058,310.00	106.6
134003	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэх	200,303,900.00	200,303,900.00		100.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		117,580,302.72		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	29.00	29.00	0.00	
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	
620002	Гүйцэтгэх ажилтан	21.00	21.00	0.00	
620003	Үйлчлэх ажилтан	7.00	7.00	0.00	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан байхгүй.

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Хөвсгөл аймгийн Тариалан сумын ЭМТ нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тэгш байдал хүртээмж чанар, аюулгүй байдлыг хангасан үйлчилгээний стандарт, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйг чандлан сахидаг чадварлаг эмч, мэргэжилтэн бүхий төрийн үйлчилгээг төлөвшүүлэхээр зорин ажиллаж байна.

Тариалан сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Иргэдийг эрт илрүүлэгт хамруулах
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй үзүүлэх
- Үйлчлүүлэгчдэд болон эмч ажилчдад ээлтэй орчин бүрдүүлэх, хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлж тасралтгүй байдлыг хангах

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 8 дугаар сард эрүүл мэндийн салбарын багц хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулж, эрүүл мэндийн даатгалын цогц шинэчлэл хийх, стратегийн худалдан авалтыг бий болгох эрх зүйн орчин бүрдүүлсэн. Шинэчлэлийн хүрээнд 2022 онд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ бүрийн өртөг, зардлыг шинэчлэн тооцож, эрүүл мэндийн байгууллагуудыг үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлээр нь Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлж байна. Үүнтэй холбогдуулан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр батлагдсан¹ 01,02 дугаар тогтоол, 2022 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр батлагдсан² тогтоолуудаар эрүүл мэндийн даатгалын багцын төлбөр хураамжийг нэмэгдүүлэн нэг иргэнд ногдох нормативаар, үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ гэсэн арга хэмжээгээр санхүүжилтийг олгож байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

1. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн.
2. Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн “Төрийн хэмнэлтийн тухай” хууль хэрэгжиж эхэлсэн.
3. Төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор тогтоосон ба 2022 оны 192 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг өөрчлөн тогтоосон байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ийн дагуу Тариалан сумын Эрүүл мэндийн төвийн даргын 2019 оны 3 дугаар сарын 19-ны өдрийн А/09 тоот тушаалаар дотоод хяналтын ажлын хэсгийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

Дотоод хяналтын ажлын хэсэг нь 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулан, тухайн онд нийт 9 заалтын хүрээнд 5 удаа хяналтыг хэрэгжүүлэн ажилласан байна. Дотоод хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүр арилгаж ажилласан байна.

Харин санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтын 1, 2 үе шатны тогтолцоо бий болсон байна гэж үзлээ. **Тухайлбал:** Санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэх удирдлага буюу эрхлэгч 1 дүгээр гарын үсэг, нягтлан бодогч 2 дугаар гарын үсэг зурж баталгаажуулж байгаа нь гүйцэтгэх удирдлагын хяналтыг хэрэгжүүлж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

¹ “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай”

² “Багц, төлбөрийн хэмжээ, журам батлах тухай”

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тариалан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар: Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа Хөвсгөл аймгийн Засаг даргын 2019 оны А/375 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэн, Эрүүл мэндийн салбарын байгууллагуудын төсвийн шатлалд өөрчлөлт орсонтой холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна. Гэхдээ санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Тариалан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 42.217,5 мянган төгрөгөөр буюу 4.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.00	117,580.3	117,580.3
Авлага	168,836.6	0	-168,836.6
Бараа материал	71,276.7	115,017.6	43,740.9
Үндсэн хөрөнгө	676,686.4	726,419.5	49,733.1
Нийт хөрөнгө	916,799.7	959,017.4	42,217.7
Өр төлбөр	0.00	100.2	100.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	916,799.6	958,917.2	42,117.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	916,799.6	959,017.4	42,217.7

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө данс өмнөх оноос нэмэгдэж, авлага данс буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

1. Тайлант онд мөнгөн хөрөнгө данс 117,580.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь эрүүл мэндийн даатгалын сангаас хүлээн авсан санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлээгүйтэй холбоотой байна.
2. Бараа материал данс өмнөх оноос 43,740.9 мянган төгрөгөөр өссөн шалтгаан нь корона вирусны үеийн бэлэн байдлын нөөц бүрдүүлэлттэй холбоотой байна.
3. Үндсэн хөрөнгө данс 49,733.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 130,340.2 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн ба төсвийн хөрөнгөөр 63,202.6 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авч, 67,137.6 мянган төгрөгийн

машин тоног төхөөрөмжийг улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр үнэ төлбөргүй хүлээн авсан байна

Өмнөх оны Эрүүл мэндийн даатгалаас авах 168,836.6 мянган төгрөгийн авлага барагдуулсан ба газрын төлбөрийн 100.2 мянган төгрөгийн байгууллагад төлөх өр үүссэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,136,105.0 төгрөг, Орон нутгийн төсвөөс 49,661.0 мянган төгрөгийн санхүүжилтийг авахаар төлөвлөсөн. Нийт зарлагыг 1,185,371.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид 2021 оны 07-р сарын 08-ны өдөр хүргүүлсэн байна.

Эрүүл мэндийн байгууллагын төсвийн төлөвлөлт нь сүүлийн 3 жилийн гүйцэтгэлээр хийгддэг тул төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 49,661.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,028,764.4 мянган төгрөгийг улсын төсвөөс орлого бүрдүүлсэн байна.

Гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын сангаас 1,198,163.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны орлого төвлөрүүлээгүй байна. Орон нутгийн төсвөөс 49,661.0 мянган төгрөгийн санхүүжилт авснаас 48,698.5 мянган төгрөгийн гүйцэтгэл тайлагнаж 567.5 мянган төгрөгийн үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,246,861.2 мянган төгрөг буюу 99.06 хувьтай байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас 4 дүгээр улирлын гүйцэтгэлийн санхүүжилт 2022 оны 12 сарын 25-ны өдөр төрийн сангийн харилцах дансанд орж ирсний улмаас төлөвлөгөөнд тусгаж зардлын эрхийг нээлгээгүй байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Нэг иргэнээр тооцсон нормативаар	530,031.6	508,360.6	21,671.0	95%
2	Үндсэн тусламж үйлчилгээ	405,769.5	489,498.8	-83,729.3	120%
4	Дээд шат нэмэлт төсөв	200,303.9	200,303.9	0	100%
5	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	49,266.1	48,698.5	567.6	98,8%
	Дүн	1,185,371.1	1,246,861.2	-61,490.7	105.1

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

2021 оны жилийн эцсээр 168,836,5 мянган төгрөгийн авлага барагдуулж нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдлийг төрийн сангийн харилцах данс руу бичилт хийж тайлагнасан байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Тариалан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах Шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хаан соёмбо аудитын ХХК-ийн захирал Х.Диймаа, аудитын менежер Л.Магсаржалам нар гүйцэтгэж, хяналтыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Давааням, аудитын менежер Б.Тэгшдэлгэр, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тариалан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хаан соёмбо аудит ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2 сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,589,568.9 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 31,791.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 буюу 22,254.0 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ 146,016.6 мянган төгрөгийн 15 гүйлгээ мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дах заалтыг зөрчсөн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалтын дагуу Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг цаг хугацаанд иж бүрэн оруулаагүй мөн Эрүүл мэндийн даатгалын сангаас авч байгаа гүйцэтгэлийн санхүүжилттэй холбоотой төсөв нэмэгдэж зарим нэг зардал дээр худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Хөвсгөл аймгийн Тариалан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага байхгүй, улсын бүртгэлийг гэрчилгээг шинэчлэх зөвлөмж өгсөн ба зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4: зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/				
	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	0.00	1	0.00	100
Нийт дүн	1	0.00	1	0.00	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийг гүйцэтгэлд суурилж олгож байгаагаас шалтгаалан, санхүүжилтийн орлого нэмэгдэж ирснээр дахин эмийн тендер зарлаж, худалдан авалт хийх шаадлагатай байсан ч, тухайн сумын Эрүүл мэндийн төв нь 83,780.6 мянган төгрөгийн тендергүй эмийн худалдан авалт, 46,730.2 мянган төгрөгийн багаж тоног төхөөрөмжийг тендергүй худалдан авалт хийсэн байна.

Аудитаар нийт 448,170.1 мянган төгрөгийн алдаа³ илэрснээс аудитын явцад 176,963.3 мянган төгрөгийн алдааг залруулж, 271,206.8 мянган төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналд гарсан дараах алдааг залруулсан. Үүнд:

- ЭМД-аас 2021 оны ковидын авлага 168,379.9 мянган төгрөг авсан ба үүнийг 2022 оны мөнгөн гүйлгээний тайланд орлогын зүйл ангийг буруу сонгож тайлагнасан нь үнэн зөв гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Тайлант онд дээд шатны байгууллагаас орж ирсэн 1,019.3 мянган төгрөгийг санхүүгийн тайланд тусгаагүй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.4.үнэн зөв байх; 5.1.5.хэмжигдэхүйц байх; заалтыг зөрчсөн ба үнэн зөв гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Тайлант онд 7564.1 мянган төгрөгийг зардал хооронд гүйлгэн эдийн засгийн ангилал буруу сонгож бүртгэснийг залруулсан болно.

Аудитаар нийт 271,206.8 мянган төгрөгийн зөрчил⁴ илэрснээс, 271,206.8 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөөгүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Өр төлбөртэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд 100.2 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэж ажилласан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг зөрчсөн ба эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийг зөв зохистой удирдаж, батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргаж, өр төлбөр үүсгэхгүй ажиллах

2. Бараа материал холбоотой асуудал

Илрүүлэлт:

Хүнсний материалыг сарын бодит хэрэглээнээс илүү 4,226.5 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1⁵ дахь заалтыг зөрчсөн ба эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Бараа материалыг их хэмжээгээр нөөцөлж, үр ашиггүй зардал гаргахгүй байх

³ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

⁴ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

⁵ "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах

3.Нийгмийн эрүүл мэндийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Нийгмийн эрүүл мэндийн зардлаас нийт 17,906.7 мянган төгрөг зарцуулсан байна. Үүнээс хүүхдийн сувилал ажиллуулсан, ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, гэр бүлийн тэмцээн зохион байгуулах, үдийн цай, хоол гэх мэт зардалд зарцуулсан 3,998.5 мянган төгрөгийн үр ашиггүй зардал гаргасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалттай нийцээгүй ба “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах,

4. Балансын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Санхүүгийн байдлын тайлан дах бараа материал, үндсэн хөрөнгийн дүн тооллогын бүртгэлийн дүнтэй таарахгүй тооллого хийсэн боловч тооцоо бодсон акт үйлдээгүй зөрүүтэй илэрхийлэгдсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, 12.2.1 “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”, 20.2.6. “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” заалтуудыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Жил бүрийн эд хөрөнгийн тооллогыг цаглаварт заасан хугацаанд тогтмол хийж үр дүнг тооцож ажиллах

5. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант хугацааны зардлыг түүвэрлэн үзэхэд цахим төлбөрийн /е – баримт/ баримтгүй 116,865.6 мянган төгрөгийн ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд бүртгэж тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалттай нийцэхгүй байгаа ба иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Аж ахуйн нэгж, байгууллагуудаас худалдан авалт хийхдээ төлбөрийн е баримтаар баталгаажуулж анхан шатны баримт бүрдүүлж ажиллах.

6. Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ 146,016.6 мянган төгрөгийн 15 гүйлгээ мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дах заалтыг зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг цаг хугацаанд иж бүрэн оруулах.

Зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 09 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЭМД-аас 2021 оны ковидын авлагыг Мөнгөн гүйлгээний орлогын тайланд зөрүүтэй тайлагнасан	2	169,399.2			1	169,399.2	1	169,399.2				
дансны харьцаа буруу хийсэн	1	7,564.10			1	7,564.10	1	7,564.10				
Дүн	3	176,963.3			3	176,963.3	3	176,963.3				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Өр төлбөр үүсгэсэн	1	100.2					1	100.2				
Сарын бодит хэрэглээнээс илүү материал нөөцөлсөн	1	4,226.50					1	4,226.50				
Төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй	1	3,998.5					1	3,998.5				
Тооллогын бүртгэлийн дүнтэй таарахгүй	1						1					
Е баримтгүй гүйлгээ хийсэн	1	116,865.6					1	116,865.6				
Нийт дүн	5	125,190.8					5	125,190.8				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
6.4.5 Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ мэдээлээгүй байна.	1	146,016.0					1	146,016.0
Дүн	1	146,016.0					1	146,016.0

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

АХЛАХ АУДИТОР

Б.ДАВААНЫМ ОГНОО:

БАТАЛГААЖУУЛСАН.

ХААН СОЁМБО АУДИТ ХХК-ИЙН

ЗАХИРАЛ

Х.ДИЙМАА ОГНОО:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Л.МАГСАРЖАЛАМ ОГНОО

